



САЙНЦАГААН СУМЫН ГУРАВДУГААР
СУРГУУЛИЙН ТӨСВИЙН ШУУД
ЗАХИРАГЧ О.ОЮУНХАНД ТАНАА

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ДУНДГОВЬ АЙМГИЙН
АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

48090 Дундговь аймаг,
Сайнцагаан сум, Нарлаг баг
Утас: 70-59-24-39, 70-59-22-08, 70-59-32-08
E-mail: dundgov@audit.gov.mn

2016.12.05 № 01/186

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.2-д заасан бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын Ерөнхий аудиторын 2014 оны 203 дугаар тушаалаар баталсан “Санхүүгийн тайлангийн аудитын журам”-ын 1.9, аймгийн Аудитын газрын 2016 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу Сайнцагаан сумын ерөнхий боловсролын гуравдугаар сургуулийн 2016 оны гуравдугаар улирлын санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн завсрлын аудитаар 241,008.00 /Хоёр зуун дөчин нэгэн мянган найман/ төгрөгийн дараах зөрчлүүд илэрлээ.
Үүнд:

1. Нярвын цалинг TY-5-1 шатлалаар тогтоож 91,008.00 төгрөгийг илүү тооцож олгосон.

Энэ нь Засгийн газрын 2007 оны 354 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн захирагааны болон төрийн үйлчилгээний албан тушаалын ангилал, зэрэглэлийг шинэчлэн тогтоох тухай” тогтоолын 7 дугаар хавсралтын 9.2 /TY шатлалд Нарийн бичгийн дарга, диспетчер, нярав, сувилагч байна/-т гэж заасныг;

2. Хөдөөгийн багш нарын спортын их наадамд төсвөөс 150,000.00 төгрөгийг зарцуулсан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.5.5 /Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах/, Монгол Улсын Их Хурлын 2016 оны 47 дугаар тогтоолын 5 /төсвийн хөрөнгөөр шууд болон шууд бус хэлбэрээр шинэ жил, баяр ёслолын аливаа арга хэмжээг санхүүжүүлэхгүй байх/-т заасныг тус тус зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-т /Аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтооомж, эрх зүйн хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих/, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2014 оны 138 дугаар тушаалаар батлагдсан Төрийн аудитын байгууллагын ажилтны нийтлэг эрх, үүргийн тухай дүрмийн 2.2.3-т /Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийг хэрэгжүүлэх хүрээнд төрийн аудитын байгууллагын ахлах аудитор, ахлах шинжээч, аудитор, шинжээч нь аудитын явцад илэрсэн төлбөрийг барагдуулах, зөрчлийг арилгуулах зорилгоор төлбөрийн акт, албан шаардлага өгөх/, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны 09 дүгээр сарын 09-ны өдрийн A/95 дугаар тушаалаар баталсан Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журмын 4.1.3-д /Төсвийн хөрөнгийг үр


100000712

ашиггүй, зориулалт бусаар батлагдсан хэмжээнээс хэтрүүлэн зарцуулж, төсвийн тухай хуулийн холбогдох зүйл заалтыг зөрчсөн/ заасныг тус тус үндэслэн ШААРДАХ НЬ:

1. Улсын Их Хурлын 47 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангаж, төсвийг үр ашигтай, зориулалтын дагуу зарцуулж ажиллах;
2. Цалинг тогтоохдоо Засгийн газрын 354 дүгээр тогтоолыг баримтлан ажиллах,
3. Албан шаардлагыг хэрэгжүүлж, биелэлтийг аймгийн Аудитын газарт 2016 оны 12 дугаар сарын 25-ны дотор албан ёсоор ирүүлэхийг Сайнцагаан сумын ерөнхий боловсролын гуравдугаар сургуулийн төсвийн шууд захирагч /О.Оюунханд/, нягтлан бодогч /Н.Бээжинсүрэн/ нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГЫГ


ӨГСӨН¹:



ЗӨВШӨӨРСӨН:

Гуравдугаар сургуулийн:

О.ОЮУНХАНД
Н.БЭЭЖИНСҮРЭН


ЗЮДОРСА



¹ Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д “Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ” гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.